



ТӨРИЙН ӨМЧИЙН 6 ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛУУДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/89, А/60, А/55
А/79, А/78, А/54

Улаанбаатар хот

Төрийн өмчийн их сургуульд докторын дараах судлаач
ажиллуулах нийтлэг журам батлах тухай

Монгол улсын Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.11 дахь заалт, 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн “Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн 2.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн өмчийн их сургуульд докторын дараах судлаач ажиллуулах үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг “Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичиг”-т хамаарах сургуулиуд санамж бичгийн хэрэгжих хугацаанд мөрдөн ажилласугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Монгол улсын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал /С.Должин/, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал /Д.Мягмарсүрэн/, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Эрдэм шинжилгээ, гадаад харилцаа хариуцсан дэд захирал /Д.Дамдиндорж/, Монгол улсын Боловсролын их сургуулийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал /Д.Наранцэцэг/, Соёл урлагийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновац эрхэлсэн дэд захирал

/Ж.Эрхэмтөгс/, Хөдөө аж ахуйн их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновац эрхэлсэн дэд захирал /Г.Гантулга/ нарт тус тус үүрэг болгосугай.

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ ПРОФЕССОР


Н.ХҮРЭЛБААТАР
УХ/00074 584646

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ДЭД ПРОФЕССОР


О.АЛТАНГОО
9087702 - 9021051159

МОНГОЛ УЛСЫН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР


Б.ОЧИРХУЯГ
1117144746
УХ/00072 9104399

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР



Т.НАМНАН
MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY
Tallin 9087887

ХӨДӨӨ АЖ АХУЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР


Т.ХЭРҮҮГА
9020070105 - 9099395

СОЁЛ, УРЛАГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР


Э.СӨНИНТОГОС
УХ/00053



ТӨРИЙН ӨМЧИЙН ИХ СУРГУУЛЬД ДОКТОРЫН ДАРААХ СУДЛААЧ АЖИЛЛУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журам нь (цаашид “журам” гэнэ) төрийн өмчийн их сургуульд докторын дараах судлаач (цаашид “судлаач” гэнэ) ажиллуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Их сургуульд докторын дараах судлаач ажиллуулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хянах, тайлагнах зэрэг үйл ажиллагааг тухайн их сургуулийн ахисан түвшний сургалт хариуцсан нэгж (цаашид “АТСХН” гэнэ) зохион байгуулна.

1.3 Докторын зэрэгтэй Монгол Улсын болон гадаадын харьяат иргэдийг докторын дараах судлаачаар ажиллуулна.

ХОЁР. Судлаачаар бүртгүүлэхэд тавигдах шаардлага

2.1 Судлаач нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1 Докторын зэрэг хамгаалснаас хойш 5 жил өнгөрөөгүй байх;

2.1.2 Докторын дараах судалгааны ажлын даалгаврыг гүйцэтгэхэд 3-аас доошгүй жил их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж байсан туршлагатай, судалгааны ажлын шаардагдах мэдлэг, ур чадвартай байх;

2.1.3 Олон улсын мэдээллийн сан (Web of Science, PubMed болон Scopus гэх мэт)-д бүртгэлтэй Q1, Q2, Q3 болон Q4 ангиллын сэтгүүл¹-д өөрийн судалгааны үр дүнгээр, эрдэм шинжилгээний 1-ээс доошгүй өгүүлэл хэвлүүлсэн байх;

2.1.4 Докторын дараах судлаачаар ажиллуулах нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн байх;

2.1.5 Эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн байх зэрэг орно.

ГУРАВ. Зохион байгуулалт

3.1 Эрдэм шинжилгээний ажил тууштай хийж гүйцэтгэх сонирхолтой, судалгаа шинжилгээний ажлын өндөр чадавхтай, докторын зэрэгтэй иргэнийг төрийн өмчит

¹ Сэтгүүлийн эрэмбийг дээрх мэдээллийн сангийн Impact Factor Journal Citation Reports (JCR), National Library of Medicine's NLM (MEDLINE) болон SCIMago Journal Rank (SJR)-аас гаргадаг жарсаалтын дагуу тооцно.)

их сургууль болон бусад байгууллагын тэтгэлгээр тухайн их сургуулийн профессор, дэд профессорын зэрэглэлд ажиллаж буй багшийн удирдлага дор судалгааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд болон тодорхой үр дүнгийн даалгаврын дагуу гэрээ байгуулан ажиллуулна.

3.2 Их сургуулийн тэнхим, лаборатори, хүрээлэн, төв, бүрэлдэхүүн сургууль (цаашид "нэгж" гэнэ) нь судлаач ажиллуулах хэрэгцээ, шаардлагыг жилээр төлөвлөж, тухайн хичээлийн жилийн 11 дүгээр сарын эхний долоо хоногт багтаан тус сургуулийн АТСХН-д ирүүлнэ.

3.3 АТСХН судлаач ажиллуулах тухай нэгжүүдээс ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тухайн хичээлийн жилд ажиллах докторын дараах судлаачийн тоо, нэрсийн жагсаалт, шаардагдах санхүүжилтийн төслийг боловсруулж, 12 дугаар сарын эхний долоо хоногт багтаан тухайн их сургуулийн зохих зөвлөл (захиргааны зөвлөл, эрдмийн зөвлөл г.м)-өөр хэлэлцүүлэх ба зөвлөлийн шийдвэрт судлаачийн харьяалагдах нэгжийн нэр, гүйцэтгэх ажлын чиглэл/төрөл, тэтгэлгийн хэмжээ, эх үүсвэр, ажиллах хугацааг нарийвчлан тодорхой тусгана.

3.4 Судлаачийн бүртгэлийг намрын улиралд 12 дугаар сарын 2 дахь долоо хоногоос 01 дүгээр сарын 2 дахь долоо хоногт, хаврын улиралд 05 дугаар сарын 2 дахь долоо хоногоос 06 дугаар сарын эхний долоо хоногт багтаан зохион байгуулж, материал хүлээн авна.

3.5 Судлаачаар бүртгүүлэхэд дараах материалыг бүрдүүлнэ.

3.5.1 Өргөдөл;

3.5.2 Төрийн албан хаагчийн анкет;

3.5.3 Докторын дипломын хуулбар /эх хувийн хамт/;

3.5.4 Бүтээлийн жагсаалт;

3.5.5 Судалгааны ажлын урьдчилсан төлөвлөгөө;

3.5.6 Докторын дараах судалгааны ажлын удирдагчийн тодорхойлолт;

3.5.7 Ажлын газрын "түр чөлөөлөх" тухай тодорхойлолт.

3.6 Зөвлөлөөр шийдвэрлэсний дагуу судлаачийг ажиллуулах нэгжээс шалгаруулалтад оролцохыг урьсан зарыг олон нийтэд нээлттэй түгээж, сонгон шалгаруулах ба шалгаруулалтыг тухайн хичээлийн жилийн 01 дүгээр сарын хоёр дахь долоо хоногт, 06 дугаар сарын эхний долоо хоногт багтаан тус тус зохион байгуулна.

3.7 Судлаачийг удирдан ажиллуулах судалгааны ажлын удирдагч профессор, дэд профессор нь шалгаруулалтад тэнцсэн судлаачтай гүйцэтгэх судалгааны ажлын агуулга, хэмжээ, ажиллах хугацаа, тэтгэлгийн хэмжээ, судалгааны ажлын үр дүнг үнэлэх дүгнэх асуудлыг тусгасан гэрээг 3 хувь үйлдэж намрын улиралд 01 дүгээр сарын 3 дахь долоо хоногт, хаврын улиралд 06 дугаар сарын 2 дахь долоо хоногт багтаан АТСХН-д хүргүүлнэ.

3.8 Судлаач ажиллуулах гэрээт ажлын үргэлжлэх хугацаа тухайн их сургуулийн 2 хичээлийн жилээс хэтрэхгүй байна.

3.9 Судлаач судалгааны ажлын үр дүн, гүйцэтгэлийн талаар хичээлийн улирал бүрийн төгсгөлд харьяалж буй нэгжийн удирдлагад тайлагнана.

3.10 Судлаач ажиллуулсан нэгж нь тухайн судлаачийн ажлын үр дүн, тайланг тухайн нэгжийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, гэрээг үргэлжлүүлэх болон дуусгавар болгох эсэх тухай шийдвэрийг хичээлийн жил бүрийн 11 дүгээр сарын эхний долоо хоногт багтаан АТСХН-д хүргүүлнэ.

3.11 Судлаач болон удирдагч нар судалгааны явцын үр дүнг хагас жил тутам АТСХН-д тайлагнана. Судалгааны төслийн тайланг их сургуулийн зохих (захиргааны, эрдмийн ... г.м) зөвлөлөөр хэлэлцүүлж хүлээлгэн өгнө.

3.12 Судлаач ажиллуулж буй их сургуулийн АТСХН нь энэ журмын дагуу үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжүүлж ажиллана.

ДӨРӨВ. Санхүүжилт

4.1 Их сургуулийн тэтгэлгээр докторын дараах судлаачаар ажиллах тохиолдолд ахлах багшийн зэрэглэлийн цалинтай тэнцэхүйц хэмжээний тэтгэлгийг сар бүр олгоно.

4.2 Тухайн судлаачийг ажиллуулж буй нэгж нь шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвтөө суулгаж санхүүжүүлнэ.

ТАВ. Талуудын эрх, үүрэг

5.1 Судлаачийн эрх, үүрэг

5.1.1 Судлаач гэрээнд заасан хугацаанд тэтгэлэг авах эрхтэй.

5.1.2 Докторын дараах судалгааны ажлыг гүйцэтгэхэд шаардагдах ажлын байр, туршилт, судалгааны орчин, эм урвалж, тоног төхөөрөмж, судалгааны материал зэргээр хангагдах эрхтэй.

5.1.3 Судлаач гэрээний хугацаанд давхар ажил эрхлэхгүй.

5.1.4 Судлаач гэрээнд заасан судалгааны ажлыг тоо, чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, судалгааны чадавхаа байнга хөгжүүлэх үүрэгтэй.

5.1.5 Судлаач нь судалгааны ажлын удирдагч профессор, дэд профессортой хамтран судалгааны ажлын төлөвлөгөө гарган, гэрээний хавсралт болгон мөрдөж ажиллана.

5.1.6 Удирдагч профессор, дэд профессорын зүгээс шаардлагатай гэж үзсэн 3 хүртэлх багц цаг бүхий хичээлийг судлаач нь тухайн судалгааны ажилтай уялдуулан нэмэлт цалин хөлсгүйгээр зааж болно.

5.1.7 Гэрээг дүгнэх үед судлаач нь удирдагч профессор, дэд профессортой хамтарсан судалгааны үр дүнгээр олон улсын сэтгүүлд нэгдүгээр эсвэл холбоо баригч зохиогчоор өгүүлэл хэвлүүлсэн (хэвлэхээр зөвшөөрөгдсөн "accepted" байж болно) байна.

5.1.8 Судлаач өөрийн судалгааны ажлын үр дүнг их сургуулийн эрдмийн

хамт олны дунд хэлэлцүүлэг, суралцагчдад семинар зохион байгуулах, зөвлөгөө өгөх байдлаар хэлэлцүүлнэ.

5.2 Удирдагчийн эрх, үүрэг

5.2.1 Удирдагч нь тухайн судлаачийг удирдах хугацаандаа нэгээс илүүгүй төрийн өмчийн их сургуулийн тэтгэлэг бүхий судлаачтай байна.

5.2.2 Тухайн судлаачийг харьяалах нэгж болон удирдагч профессорын зүгээс судалгааны ажлын үр дүнтэй холбоотой нэмэлт шаардлагыг тавьж болно.

5.2.3 Удирдагч профессор, дэд профессор нь судлаачийн судалгааны ажлын явц, үр дүнг хичээлийн жилийн улирал бүр дүгнэж, цаашид гэрээг үргэлжлүүлэх эсэх шийдвэрийг судлаач ажиллуулж буй нэгжийн удирдлагад тухай бүрт танилцуулна.

5.2.4 Судлаач нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, энэхүү журмын 5.1.6, 5.3.4-д заасан бүтээлийг хэвлүүлж чадаагүй тохиолдолд тухайн судлаачийг удирдан ажиллуулсан профессор, дэд профессор гэрээнд заасан үр дүнг хүлээлгэн өгөх хүртэл хугацаанд дахин докторын дараах судлаач удирдан ажиллуулах, тухайн их сургуулийн санхүүжилттэй аливаа төсөл, хөтөлбөрт өрсөлдөх эрхгүй болно.

5.3 Сургуулийн эрх, үүрэг

5.3.1 Судалгааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буй их сургуулийн үндсэн орон тооны профессор, дэд профессорын албан тушаалын зэрэглэлд ажиллаж буй багш докторын дараах судлаач удирдан ажиллуулна.

5.3.2 Тухайн сургууль нь гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг судлаачаас шаардах эрхтэй.

5.3.3 Судлаачийг ажиллуулж буй нэгж нь тухайн судлаачийг ажиллуулах шаардлага, эрэлт хэрэгцээг судлан тодорхойлох, судлаачид шаардлагатай мэдээллээр хангах, ажил үүргээ гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

5.3.4 Гэрээний үр дүнд хүлээлгэн өгөх бүтээлийн чанарыг үнэлэхдээ олон улсын мэдээллийн сан (Web of Science, PubMed болон Scopus гэх мэт)-д бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн эсэх, тухайн сэтгүүлийн ранк (Q1, Q2, ... г.м) зэргийг ашиглана.

ЗУРГАА. Бусад

6.1 Судлаач ажиллуулах нөхцөл болон судлаачид тавигдах нэмэлт шаардлагыг түүнийг удирдан ажиллуулах сургууль, нэгж тусгайлан тавьж болно.

6.2 Тухайн их сургуулиас бусад байгууллагын тэтгэлгээр докторын дараах судлаачаар ажиллах тохиолдолд тэтгэлгийн хэмжээ болон хугацааг гэрээгээр зохицуулна.

х х х